

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2024 оны 12 дүгээр сарын 16

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 10 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хяналт шинжилгээний ажлыг **гүйцэтгэхдээ** Засгийн газрын 2020 оны 2062021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийв.

Хяналт шинжилгээ хийсэн талаар:

Нийт 10 арга хэмжээний хэрэгжилт нь 100%-7, 90%-1, 70%-1, 30%-1 арга хэмжээ тус тус ханган ажилласан бөгөөд ерөнхий үнэлгээгээр 89%-ийн хэрэгжилттэй байна

“Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лаборатори шинээр байгуулах” арга хэмжээний үйл ажиллагаанд дан ганц манай байгууллагаас шалтгаалах бус бусад дээд шатны байгууллагатай хамтран шийдвэрлэх буюу хэрэгжилтийг хангахад шаардагдах төсөв шийдэгдээгүйн улмаас удаашралтай байгаа тул нэгж, газрын удирдлагууд анхаарах, цаашид эрчимжүүлэх санал хүсэлтийг холбогдох газруудад яаралтай хүргүүлэн ажиллах шаардлагатай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,
ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Д.МӨНХБААТАР

Г.АРИУНТУНГАЛАГ

Г.ДӨЛГӨӨН

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН
2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 13-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар	ХБТББ-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэг-жих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.т өг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13

АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛ

Салбарын үр дүн: Агаар дахь тоосонцорын агууламжийг 25 хувиар бууруулна.

242	АХ-2.5.9, НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан түлшний нөөц бүрдүүлэх, борлуулалтын цэлийн тоог нэмэгдүүлж, түгээх, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих	2024	НАОБТГ	НТ	37,567.6	Тээвэрлэсэн түлшний хэмжээ	643,104	32,000.0	21,690,0	Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Эрх шилжүүлэх тухай" А/118 дугаар захирамжаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулахыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, гэрээ байгуулан 7 дүүргийн хэмжээнд 2024-2025 онд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх 30 багц ажлыг www.tender.gov.mn-д зарлаж 29 тээврийн компанийг хуулийн хүрээнд сонгон шалгаруулж "Сайжруулсан шахмал түлш тээвэрлэх гэрээ"-г байгуулсан. 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 2025 оны 12 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар 29 тээврийн компани нь зүүн болон төвийн бүсийн үйлдвэрээс эцсийн борлуулалтын цэг, алуулахад нийт 605,493 тонн сайжруулсан шахмал түлшийг тасралтгүй тээвэрлэн ажиллаж байна. НАОБТГ нь сайжруулсан шахмал түлш	90
-----	--------------------------------------	---	------	--------	----	----------	----------------------------	---------	----------	----------	--	----

									ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 5,523 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна.		
									Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд 2024-2025 онд сайжруулсан шахмал түлш борлуулагч 670 борлуулалтын цэгийг нээн ажиллуулахаар төлөвлөснөөс 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар 582 цэг ажиллуулаад байна. Гэр хорооллын 203,683 айл өрхөд сайжруулсан шахмал түлшийг ханган нийлүүлж, борлуулалтын цэгийн өдөр тутмын түлшний татан авалт, борлуулалтад хяналт тавин ажиллаж байна. Борлуулалтын урамшуулалд нийт 6,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.	90	
						Борлуулалт	460,000	9,527.7	6,000.0		
243		Ерөнхий боловсролын 143 дугаар сургуулийн халаалтын зуухыг буулгаж, төвлөрсөн дулаан хангамжид холбох зураг төсөв боловсруулах	2024	НАОБТГ	НТ	200.0	Төвлөрсөн дулаанд холбосон зуух	-	-	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн “Агаар, орчны бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөрийн зардлын хуваарь батлах, эрх шилжүүлэх тухай” А/163 тушаалаар Ерөнхий боловсролын 143 дугаар сургуулийн халаалтын зуухыг буулгаж, төвлөрсөн дулаан хангамжид холбох зураг төсөв боловсруулах ажлын санхүүжилтийг шийдвэрлэн, зураг төсөв гүйцэтгэх байгууллагын сонгон	70

									шалгаруулахаар үнэлгээний хороонд хургуулсан бөгөөд тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүд шаардлага хангаагүй тул тендерийг дахин зарлаад байна.		
		Урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний чанар стандартын шаардлага хангаж буй байдалд тогтмол хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна. 2024 оны 01 дүгээр сарын 15-аас 12 дугаар сарын 13-ны байдлаар Төв, Зүүн Баруун бүсийн үйлдвэрийн үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлшний 26, 11, мидлингийн барьцалдуулагчийн 10 дээж нийт 47 дээжид Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газрын төв лаборатори, Хими, химийн технологийн хүрээлэнгийн итгэмжлэгдсэн лабораторид тус тус техникийн шинжилгээг хамруулахад Лабораторийн шинжилгээний сорилын дүнгээр тус дээжүүд MNS5679:2022 “Сайжруулсан хатуу түлш. Техникийн ерөнхий шаардлага” стандартыг хангаж байх тул улсын /ахлах/ байцаагчийн 14 дүгнэлт гаргаж холбогдох байгууллага, алба хаагчид хүргүүлэн ажиглалаа.									
244	АХ-2.5.9, НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1	Таван толгой түлш ХХК-ний үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлш, түүний түүхий эдээс дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулж үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	2024	НАОБТГ	НТ	5.0	Шинжилгээн д хамруулсан дээж	-	-	-	100
245		Уурын болон 100кВт-аас дээш	2024	НАОБТГ	НТ	80.0	Хэмжилт хийсэн зуух	-	-	-	100

	Ба доош хүчин чадалтай усан халаалтын зууханд хэмжилт хийх							нэгж байгууллагын хүсэлтээр 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 28-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 35 зууханд хэмжилт хийж MNS 5043:2016, MNS 5919:2009, стандартад заасан үзүүлэлттэй харьцуулан хэмжилтийн дүнг боловсруулсан. Хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулахад шаардлага хангаагүй 15 зуух байна. Хэмжилтийн орлого 8 сая төгрөгийг Нийслэлийн төсөвт төвлөрүүлэн ажилласан.			
	Уурын болон 100кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зууханд хяналт шалгалт хийх	2024	НАОБТГ	НТ	20.0	Хяналт шалгалт	280	20,0	20,0	Урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд алгаар бохирдуулагч эх үүсвэр ашиглагч нийт 550 объектод хяналт шалгалт хийснээс 28 Иргэн, Аж ахуйн нэгж байгууллагад Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 24300 нэгжийн торгууль ногдуулж улсын байцаагчийн албан даалгавар хүргүүлсэн, Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл томлын дагуу 61 Иргэн, Аж ахуйн нэгж байгууллагын халаалтын зуух болон баримт бичигт хяналт шалгалт хийснээс 3ТХ-ийн холбогдох заалтын дагуу 8 Иргэн, Аж ахуйн нэгж байгууллагад 7150 нэгжтэй тэнцэх торгууль ногдуулж улсын байцаагчийн хугацаатай албан даалгавар хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу	100
246											

									хилбаршуулсан журмаар 32 арга хэмжээ ногдуулж, Зөрчлийн хэрэгт 5 Иргэн, Аж ахуйн нэгж байгууллагад нээн холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж, 1 аж ахуйн нэгж байгууллагын зөрчлийн хэрэг нээн зөрчилт шалтан шийдвэрлэх ажиллагаа явуулахад зөрчлийн шинжгүй байх тул хэрэгсэхгүй болгосон байна. Мөн 1 иргэнээс ирүүлсэн 1 томдол мэдээлэл зөрчлийн шинжгүй байх тул томдол мэдээллийг хүлээн авахаас татгалзах тогтоол үйлдэж нийслэлийн прокуратурын газарт хүргүүлсэн ажилласан.	
									Зөрчлийн үр дагаврыг арилгах, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай улсын байцаагчийн 3 заалттай албан шаардлагыг 25 аж ахуйн нэгжид хүргүүлэн, 60 аж ахуйн нэгжид хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай зөвлөмж хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.	
247	Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо, хяналтын цэгүүдэд түүхий нүүрсний хяналт тавих ажлыг үргэлжлүүлэх	2024	НАОБТГ	НТ	-	Шалгасан тээврийн хэрэгсэл	-	-	2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн Авто тээврийн шалган нэвтрүүлэх 7 товчоо, хяналтын цэгт хяналт шалгалтыг дахин хийж хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Нийслэлийн Засаг Даргын А/1000 захирамжийн хүрээнд Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын сайжруулсан түлшний хяналтын хэлтсийн гэрээт 28 хяналтын ажилчдаар 2025 оны 05 дугаар сарын 15-ний өдрийг дуустал	100

									ажлуулхаар шийдвэрлэсэн.			
248	АХ-2.5.9, НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1	Автозамын хөдөлгөөнд оролцож буй дизель хөдөлгүүрт нийтийн болон ачаа тээврийн хэрэгслийн хаягдал утааны агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалт хийх	2024	НАОБТГ	НТ	5.0	Тээврийн хэрэгсэл	-	-	-	Авто замын хөдөлгөөнд оролцож буй дизель хөдөлгүүрт нийтийн болон ачаа тээврийн хэрэгслийн хаягдал утааны агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалт урьдчилсан удирдамжийн хүрээнд Зорчигч Тээвэр- 1, 2 ОНӨААТҮГ, АПУ ЖК-ий нийт 455 тээврийн хэрэгсэл хамрагдаж, холбогдох баримт бичигт хяналт шалгалт хийж хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.	100
249	АХ-2.5.9, НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1	Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	2024	НАОБТГ	НТ	150,0	Зохион байгуулсан арга хэмжээ	-	150,0	139,0	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 -ний өдрийн “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах А/1015 захирамжийн хүрээнд: 1. “Ногоон технологи-2024” үзэсгэлэнг 9 дүгээр сарын 18,19-нд Сүхбаатарын талбайд зохион байгуулж 85 н аж ахуй нэгж байгууллага, 5000 гаруй иргэдийг хамруулсан. Мөн угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлбэ, зуухаа зөв галлах зааварчилгаа, байшин сууц хаагуураа дулаанаа алддаг талаар, хямд аргаар хэрхэн гэрээ дулаалах зэрэг мэдээлэл багтаасан нийт 1200 гаруй брошурыг иргэд олон нийтэд танилцуулж тараан хүргэсэн.	100

										Мөн Өглөө.мн, Улстөрч агентлаг.мн, Монголынмэдээ.мн, setime.mn зэрэг тус тус сайтуудаар тус өдөрлөгийн талаар видео болон арилцлага үйл явдлын мэдээ, сурвалжлага зэрэг мэдээллийг олон нийтийн хэрэгслээр түгээж нийт 10,000 гаруй иргэд олон нийтэд хүрсэн байна. 2. Гэр дулаалах заавар зөвлөмж бүхий видео болон постерийг цахим хуудсаар дамжуулан 2.0 сая хүнд хүрч 40.000 хүн хариу үйлдэл үзүүлж, 14,300 хүн бусадтай хуваалцаж, 700 гаруй хүн сэтгэгдэл үлдээж иргэд олон нийтэд сурталчилж ажилласан болно. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээ мэдээллийг Mobicom Монголын үүрэн холбооны сүлжээгээр текстэн мессэжийн хэлбэрээр Юнивайшн, ДДИШ компанийн 'IPTV LOGIN SCREEN'-д постер зурган хэлбэрээр, MGL FM радиогийн эфирээр, сайжруулсан түлшний зөв хэрэглээг иргэдэд сурталчлах, мэдээ мэдээллийг Shig.mn, Boloood.mn вебсайт, пэйж, групп хуудас, youtube сувагт байршуулж давхардсан тоогоор 1,140,000 орчим иргэд олон нийтэд хүргэсэн.	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

250	Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лаборатори шинээр байгуулах	2024	НАОБТГ	НТ	1,000.0	Лаборатори байгуулах ажлын явц	-	-	-	2024 онд шинээр лабораторийн барилга барихаар төлөвлөж 2025 оны төсөвт санал өгсөн болно.	30
251	Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн НЭГДСЭН ТОО бүртгэлийг зохион байгуулах	2024	НАОБТГ	НТ	50.0	Үйл ажиллагааны хэрэгжилт	100	20,0	20,0	Нийслэлийн Засаг даргын 202 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоо бүртгэл хийх тухай” А/1313 дугаар захирамжийн хүрээнд 2023 оны тоо бүртгэлээр 3-15кВт хүчин чадалтай ахуйн хэрэглээний 151,813 зуух, 16-100 кВт хүчин чадалтай 2,666 зуух, 100 кВт-аас дээш хүчин чадалтай 342 усан халаалтын зуух, Дулааны цахилгаан 6 станцын 4200 кВт-аас дээш хүчин чадалтай 41 зуух, агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэр нийт 716,977 тээврийн хэрэгсэл тус тус тоологдож, мэдээллийн санг шинэчлэн ажилласан. Эх үүсвэрийн тоо бүртгэлээр ердийн галлагаатай 3-15 кВт хүртэл хүчин чадалтай зуух өмнөх онтой харьцуулахад 2,5%-иар, усан халаалтын зуух 15-100 кВт, 100-4200 кВт хүчин чадалтай зуух нь 24,3%-иар буурсан тоон үзүүлэлттэй байна. Нэгдсэн дүн мэдээг Цаг уур, орчны шинжилгээний газарт 2024 оны 03 дугар сарын 15-ны өдрийн 01/97 тоот албан	100

